



**“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хог хаягдлын тухай хууль, Байгаль Орчин Аялал Жуулчлалын сайдын 2018 оны А/445 дугаар тушаалын хавсралт Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан зааврын 3 дугаар зүйлийн 3.7 дугаар хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 14 дүгээр тогтоол, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дүрмийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төвлөрсөн хогийн цэгүүдэд мөрдөх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. “Төвлөрсөн хогийн цэгүүдэд мөрдөх журам”-ыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


3. Уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төвлөрсөн хогийн цэгийн менежментийн алба (Г.Ганбилэг)-д даалгасугай.

ДАРГА



Г.УУГАНБАЯР

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын
даргын 2025 оны 09 дугаар сарын 23-ний
өдрийн 163 дугаар тушаалын хавсралт



ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГҮҮДЭД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь Нарангийн энгэр, Цагаандаваа, Мориндавааны төвлөрсөн хогийн цэгүүдэд хог хаягдал буулгаж дарж булшлуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгсэл тэдгээрийн жолооч, цуглуулагч, ачигч, хоёрдогч түүхий эд цуглуулагч болон үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын хооронд үүсэх харилцаа, чиглэл, хариуцлагыг Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Барилгын тухай хуулиуд болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн ойлголтоор хангуулахад оршино.
- 1.2 Энэхүү журамд ашиглагдаж байгаа нэр томъёог Хог хаягдлын тухай хуульд зааснаар ойлгоно.

Хоёр. Төвлөрсөн хогийн цэгүүдийн хамгаалалтын бүсэд тээврийн хэрэгсэл болоод иргэдийг нэвтрүүлэх

- 2.1 Хог тээврийн машин болон ачигч, жолооч, түүхий эд цуглуулагч болоод хөрсөөр дарж булах үйлчилгээ авч байгаа иргэд аж ахуйн нэгжүүд нь хог хаягдал бүхий тээврийн хэрэгслийг авто пүү дээр гаргаж хэмжилт хийлгэж, цахим мэдээллийн санд бүртгүүлсэн байна.
- 2.2 Хог хаягдал буулгахаар нэвтрэхдээ тухайн хог хаягдлын эх үүсвэр нэр төрлийн талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд хогийн цэгийн диспетчер болон мэргэжилтэн нар тухайн хог хаягдлыг шалгаж биологийн, химийн болон аюултай шатах, дэлбэрэх эрсдэлтэй хог хаягдал илэрвэл төвлөрсөн хогийн цэг рүү нэвтрүүлэхгүй.
- 2.3 Төвлөрсөн хогийн цэг рүү нэвтэрсэн бол хог тээврийн машиныг жолооч ландфилл хариуцсан мэргэжилтэн болоод хогийн цэгийн талбайн чиглүүлэгчийн удирдамж болон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тухай бүр заасан тодорхой хэсэгт зориулалтын дагуу ачиж, хучсан хог, хаягдлыг буулгана.
- 2.4 Ландфилл хийгдэж буй талбайд тээвэрлэлт хийх үед тухайн өдрийн онцлог үйл ажиллагаа, төлөвлөгөөт нөхцөл байдал болон буулгах хогны төрөл /энгийн,

барилгын хатуу, шингэн, үнс нурам/ зэргээс хамаарч буулгах талбайг тухай бүр чиглүүлсэн газарт төвлөрүүлэн буулгана.

2.5 Талбайд хамаарал бүхий /төвлөрсөн хогийн цэгийн менежментийн албаны/ үйл ажиллагаа явуулж байгаа техник, тоног төхөөрөмж, машин механизмыг хэвийн аюулгүй, тасралтгүй ажиллахад саад учруулахгүй байж ландфиллын үйл ажиллагааг аливаа хэлбэрээр тасалдуулалгүй байх.

2.6 Хог тээврийн автомашинууд нь төвлөрсөн хогийн цэгүүдийн бүсэд тээврийн хэрэгслийн хурдыг 5 км/цаг байхаар тохируулах

2.7 Бүртгэлгүй, гэрээ байгуулж баталгаажуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, нь хог хаягдлын төлбөрийг төлөхдөө Хог хаягдлын тухай хуулийн 9.1.4 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 50 дугаар тогтоолд зааснаар 1 тонн тутамд /энгийн хог хаягдал/ 6364 /зургаан мянга жаран дөрөв/ төгрөг нэгж тарифаар тооцож, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ийн дансанд тушааж, баримт авсан байна.

2.8 Төвлөрсөн хогийн цэгүүдэд ажиллаж байгаа хоёрдогч түүхий эд цуглуулагч нар нь нэгдсэн бүртгэл хөтөлж эрүүл, аюулгүй байдлаа хувь хүн тус бүр хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

2.9 Хогийн цэг дээр үүсэж болох эрсдэлээс хамгаалж, хог тээврийн автомашин болон өөрөө буулгагч нь тээвэрлэж ирсэн хог хаягдлаа бүрэн буулгаж дуусах хүртэлх аюулгүй байдлаа хангаж ажиллана.

2.10 Хог хаягдлаа хаяж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслийн жолооч тухайн цэгт ажиллаж байгаа “Талбайн чиглүүлэгч”-ийн зааснаас бусад газар хог хаягдал буулгасан нь тогтоогдвол торгох арга хэмжээг авах

2.11 Хогийн цэг рүү нэвтэрч буй тээврийн хэрэгсэл болоод түүнийг хариуцагч жолооч, цуглуулагч ачигч нар нь аливаа согтууруулах, мансууруулах болоод сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэсэн байх нь тогтоогдвол талбайд нэвтрүүлэхгүй.

2.12 Халуун үнс, нурам бүхий хог хаягдал бүхий хог тээврийн авто машиныг талбай руу нэвтрүүлэхгүй бөгөөд нэвтэрсэн нь талбайд гал түймэр гарах үндэс болсон нь тогтоогдвол тухайн гал унтраахад гарсан бүхий л зардлыг тухайн иргэн, аж ахуйн нэгж, түүний хамаарал бүхий жолоочоор нөхөн төлүүлэх үндэс болно.

2.13 Хог хаягдлыг зориулалтын буюу төвлөрсөн хогийн цэгт буулгаснаар тухайн тээвэрлэгдэж ирсэн хог хаягдлын үүсгэгч этгээдийн өмчлөх эрх дуусгавар болно.

2.14 Төвлөрсөн хогийн цэг рүү нэвтэрсэн иргэн аж ахуйн нэгж нь өөрийн хариуцсан, түрээсэлсэн болон ашиглаж байгаа машин техникийн хэвийн үйл ажиллагааг хангана.

Гурав. Хог хаягдлын төвлөрсөн хогийн цэгүүдэд хориглох үйл ажиллагаа

3.1 Дарж булахыг хориглох хог хаягдал Үүнд:

3.1.1 Аюултай хог хаягдал

3.1.2 Халдвартай хог хаягдал

3.1.3 Шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал

3.2 Ил задгай хог хаягдлыг шатаах

3.3 Зөвшөөрөлгүйгээр урьдчилан мэдэгдэлгүйгээр мал амьтны гаралтай сэг зэм, дайвар бүтээгдэхүүн, арьс шир бүхий хог хаягдлыг хүлээж авахгүй, талбайд нэвтрүүлэхгүй байх

3.4 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үүр болон хог хаягдал хүлээн авч буй талбайд ил гаргах, тамхи татах болон шатах тослох материал агуулахгүй байх

3.5 Төвлөрсөн хогийн цэгүүд буюу тэдгээрийг хариуцагч байгууллагын аливаа зөвшөөрөл холбогдох баримт бичиггүй золбин нохой, муур устгал явуулахгүй байх.

3.6 Золбин нохой, муур устгалын тээвэрлэлт хийж буй техник хэрэгслүүд тогтоосон цэгт ариутгал халдваргүйжүүлэлт зохих журмын дагуу хийх ба халдваргүйжүүлэлт хийлгүй хөдөлгөөн оролцохыг хориглоно.

3.7 Төвлөрсөн хогийн цэгийн талбайд барих хурдны дээд хязгаар 10км/цаг байх бөгөөд хурд хэтрүүлэхийг хориглоно.

3.8 Байгууллагын хөрөнгө бүхий хамгаалалтын хашаа хайсыг санаатайгаар болон санамсаргүй байдлаар унагах, эвдэх, орц гарц үүсгэхийг хориглоно.

3.9 Хог тээврийн авто машины тэвш дээр гарч суух, зүүгдэх, буулгах үед тэвшний ойр орчим байхыг хориглоно.

3.10 Хог хаягдал бүхий ланфиллын талбайд ил задгай хоол, хүнс зарах, архи дан согтуурахыг хориглоно.

3.11 Төвлөрсөн хогийн цэгийн ажилтан албан хаагч нарт шахалт үзүүлэх, ашиг сонирхолд нөлөөлөхийг хориглоно.

3.12 Түрэх, дарах, булах үйл ажиллагаа явуулж байгаа /үзэгдэх орчны хязгаарлагдмал хэсэгт тоос, шороо г.м/ техник хэрэгслийн ажиллах хэсэгт **200 метр** хүртэлх радиуст нэвтрэхийг хориглоно. Тухайн хэсгийг эрсдэл өндөртөйд тооцно.

3.13 Төвлөрсөн хогийн цэгүүдийн ажлын байр, талбайд байршуулсан хяналт, хамгаалалтад ашиглагдах камерын чиглэл болоод байршлыг дур мэдэн өөрчлөх, унтраах, эвдлэх зэрэг үйлдэл гаргахыг хориглоно.

Дөрөв. Хариуцлага

4.1 Энэхүү журам нь Хог хаягдлын тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүдийг тэдгээрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн байна.

4.2 Төвлөрсөн хогийн цэгийн талбайд нэвтэрсэн хог тээврийн хэрэгсэл нь хог хаягдлын төрлөөс хамаарч /Хогийн цэгийн бүсэд нэвтэрснээр чиглүүлэгчийн зааврын дагуу ачиж ирсэн хогийг буулгах бөгөөд дээрх зааврыг дагаж мөрдөөгүйгээс үүсэх гэм хорыг бүрэн хариуцна.

4.3 Тухайн журмыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ийн Төвлөрсөн Хогийн Цэгийн Менежментийн албаны албан хаагч болоод гэрээ байгуулснаас үл хамаарч төвлөрсөн хогийн цэгүүдрүү нэвтэрч буй иргэн, аж ахуйн нэгжүүд дагаж мөрдөж хэрэгжилтийг хангана.

4.4 Хогийн цэгийн талбайд тэжээвэр мал амьтан оруулсан бол холбогдох хууль дүрмийн дагуу зохих газарт мэдэгдэж арга хэмжээ авхуулна.

4.5 Хог хаягдлын тухай хууль зөрчигчдөд Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд холбогдох байгууллагад шилжүүлнэ.